



INVESTOR NATION



I УЛИРЛЫН 20 ТАЙЛАН 24

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ИЛГЭЭЛТ**

2	Б.ЗОЛБОО, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ
---	--

БИДНИЙ ТУХАЙ

7	АЛСЫН ХАРАА
8	ЗОРИЛТ
9	ҮНЭТ ЗҮЙЛС
10	МӨРДӨХ ЗАРЧИМ
10	ДАВУУ ШИНЖ ЧАНАР
11	ЧОНЫН БИЛЭГДЭЛ
12	ТОВЧ ТҮҮХ
13	ХҮНИЙ НӨӨЦ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

15	БАНКНЫ КЛАСТЕР
16	ДААТГАЛЫН КЛАСТЕР
17	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ КЛАСТЕР

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

#БИДИЛҮҮБАЙЖЧАДНА	20
БОЛОВСРОЛ	21
БАЙГАЛЬ ОРЧИН	22

НЭГТГЭСЭН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

АРД АПП	24
БҮТЭЦ	25
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ	26
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ - AARD	27

**ТУСДАА САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

ОРЛОГЫН ТАЙЛАН	29
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	30
ҮНЭЛГЭЭ	31

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

01

06

14

19

23

28

32



Гүйцэтгэх Захирлны ИЛГЭЭЛТ

Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ!

Монгол Улсын эдийн засаг 2023 онд 7 хувиар буюу 2022 оны 5.0 хувьтай харьцуулахад мэдэгдэхүйц өссөн бөгөөд үүнд уул уурхай болон экспортын эрчимжилт голлох нөлөөтэй байлаа. Гэсэн хэдий ч цаг агаарын гэнэтийн, таагүй нөхцөл байдал үргэлжилснээс үүдэн хөдөө аж ахуйн салбар тасралтгүй уналтад орсон нь 2023 оны эдийн засаг таамаглаж байснаас багаар өсөхөд хүргэлээ. Эдийн засгийн гадаад эрсдэл, тодорхойгүй байдал, түүний дотор БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаа нь уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Улмаар олон улсын байгууллагууд болон Төв банкнаас Монгол Улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийг 2 орчим хувиар бууруулж, 4-5 хувь байхаартаамагласан байна.

Төв банкнаас эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад хүчин зүйл, инфляц, эдийн засгийн төсөөллийг харгалзан бодлогын хүүг 2024 оны 3-р сард нэг нэгж хувиар бууруулж 12 хувь болгох шийдвэр гаргасан. Үүнийг харгалзан, Ард Кредит болон Ард Актив хадгаламж, итгэлцлийн хүүг хугацаанаас нь хамааруулан 1-2 хувиар бууруулах хам хийсэн бөгөөд хаалттай бондын купоны өгөөжийг мөн 5-р сараас эхлэн бууруулж, биржийн бус зах зээлийнхүүтэй дүйцүүлээд байна.

Экспорт эргэж сэргэсэнтэй холбоотойгоор урсгал тэнцэл ашигтай гарч, 2023 оны эцэс гэхэд гадаад валютын нийт нөөц түүхэн дээд хэмжээгээ давж, 4.9 тэрбум долларт хүрчээ. Түүхий эдийн үнэ уналттай байгаа хэдий ч уул уурхайн экспортын өсөлт, Хятадын нүүрсний эрэлт, Оюутолгойн зэсийн экспорт нэмэгдсэн нь тус сөрөг нөлөөллийг бууруулахад тусалсан. Гэсэн хэдий ч гадаад валютын нөөц нь 4.4 сарын импортын хэрэглээтэй тэнцэж байна.

Инфляц аажмаар буурч, өнгөрсөн оны 12-р сард 7.0 хувьд хүрсэн. Монгол банкны мөнгөний хатуу бодлого, гадаад худалдааны тэнцэл сайжирсан, түнш орнуудын инфляц буурсан, төгрөгийн ханш чангарсан зэрэг нь инфляцыг бууруулахад голлон нөлөөлжээ. Мөн 2022 оны сүүлийн саруудад өндөр өсөлттэй байсан гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ 2023 онд тогтворжиж дотоодын хүнсний инфляцыг бууруулсан. Тээврийн зардал, төгрөгийн ханш, гадаад худалдааны үнэ зэрэг гадаад хүчин зүйлсээс хамаарсан үнийн дарамт багасч, инфляцын түвшин цаашид ч буурах хандлагатай байна. Тиймээс энэ онд инфляц Төв банкны зорилтот хэмжээ болох $6 \pm 2\%$ -д хэлбэлзэхээс гадна цаашид аажмаар буурсаар 2026 оны сүүлийн хагаст зорилтот төвшинд хүрэх хүлээлтийг үүсгэж байна. Гэвч цаг агаарын хүнд нөхцөл байдал, цалингийн нэмэгдэл, ногдол ашиг хуваарилалт зэрэг дотоод хүчин зүйлүүдээс шалтгаалж инфляц суурь түвшнээс өндөр өсөх ч эрсдэл байсаар байгааг мартаж болохгүй.

Түүнчлэн ирэх 6-р сард болох УИХ-ын сонгуульоны сүүлийн хагаст инфляцид нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт бага зэрэг саарсан бол зээлийн эрэлт өндөр хэвээр байна. М2 мөнгөний нийлүүлэлт 2023 оны эцэст 26.8 хувьтай байсан бол 1-р сард 26.1 хувь болж бага зэрэг буурчээ. Банкны системийн зээл олголтын өсөлт 1-р сард 23.5 хувьд хүрсэн бөгөөд үүнд хэрэглээний болон хадгаламжийн зээл голлон нөлөөлсөн байна. Өнгөрсөн оны эхний гурван улиралд бага түвшинд байсан бизнесийн зээл оны сүүлийн хоёр сард нэмэгдэж, энэ оны 1-р сард 15.6 хувьд хүрчээ. Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл зэрэг эдийн засгийн бүх салбарт зээл олголт нэмэгдсэн байна. Нийт зээл олголтын 60 орчим хувийг хэрэглээний болон ипотекийн зээл эзэлж байна.

Ам.долларын ханш зургаан сар гаруй хугацааны турш буурч, 2024 оны 3-р сарын байдлаар 3,376.7 болж, оны эхэн үеэс 34 төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Төгрөгийн ханш чангарсан шалтгаан нь нүүрсний экспортын хэмжээ өсч улмаар экспортын орлого нэмэгдэж, өнгөрсөн 14 сарын хугацаандашигтай гадаад валютын урсгал орж ирсэнтэй холбоотой. Мөн сүүлийн 16 сарын хугацаанд гадаад валютын албан нөөц нэмэгдэж, 2024 оны 3-р сарын байдлаар түүхэн дээд хэмжээ буюу 5.2 тэрбум ам.долларт хүрчээ.

Нэгдлийн хэмжээнд эхний улиралд өнгөрсөн жилээс эхлүүлсэн байгууллагын бүтцийн оновчлол, дотоод зохион байгуулалтын өөрчлөлтийг эцэслэн дуусгахын зэрэгцээ харилцагчид үйлчлэх болон арын албадын үйл ажиллагааг системчлэх, 2023 оны санхүүгийн жилийг хаах, батлагдсан OGSМ болон бизнес төлөвлөгөөнд үндэслэн 2024 оны үйл ажиллагаагаа төлөвлөх зэрэгт анхаарч ажиллаа.

Өнгөрсөн оны сүүлээр ГрэйпСити Монгол ХХК, Даац Инвестмент ХХК (УБҮЦБ-ийн толгой компани), Крипто Үндэстэн ХК, ТэнГэрЛиг Медиа Нэгдэл зэрэг санхүүгийн бус компаниудыг хөрөнгийн биржид бүртгэлтэй Хөвсгөл ХК-ийн дор шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэв. Даац Инвестмент ХХК-ийн хувьд шийдвэр эцэслэгдээгүйн улмаас, мөн санхүүгийн тайланд аудит хийгдэж байгаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийг харахан бүртгүүлээгүй байна. Хөвсгөл ХК-ийн хувьд уул уурхайн болон ухаалаг хотын төслүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хөрөнгө оруулалтын багц дахь компаниудын, тэр дундаа Крипто Үндэстэн ХК-ийн эзэмшлийн компаниудын үйл ажиллагааг оновчтой болгох хэд хэдэн ажлыг төлөвлөөд байна. Үүний зэрэгцээ Хөвсгөл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 4-р сарын сүүлээр зохион байгуулсан бөгөөд тус хурлаар хэлэлцсэн хамгийн гол асуудлуудын нэг нь өнгөрсөн онд өрөөр шилжүүлэн авсан хөрөнгийг оны сүүлийн хагаст барагдуулах зорилгоор нэмж хувьцаа гаргах асуудлыг шийдвэрлэсэн нь байлаа.

Ард Кредитээр ахлуулсан мерчантын баг томоохон дэлгүүр, худалдааны төвүүдийг эгнээндээ нэгтгэж, хялбар интернэт банкны шийдлийг санал болгож, амжилттай хамтран ажилласаар байна. Одоогийн байдлаар жижиг, дунд бизнесүүдийг дэмжих зорилгоор “өөрөө бүртгүүлэх” шийдэл санал болгохоор төвлөрөн ажиллаж байна. Мөн бид зээл, даатгал зэрэг санхүүгийн бүтээгдэхүүнээ хамтарсан бизнесүүдэд санал болгох замаар харилцан ашигтай хамтралыг бий болгож байна.

Өнгөрсөн оны сүүлээр хэрэгжиж эхэлсэн Түмэн Ард хөтөлбөрт одоогийн байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 4,000 орчим Ардын брокерууд хамрагдаад байна. Эдгээр брокерууд өөрсдийн хүрээллийг бий болгохын зэрэгцээ манай апп, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилж байгаа билээ. Энэ нь манай эко системд санхүүгийн сайн зуршлыг төлөвшүүлэхэд өөрсдийгөө болон бусдыг урамшуулдаг хэрэглэгчдэд зориулсан урамшуулалд суурилсан санаачилга юм. Хэрэглэгчид тоглоомын (Gamification) зарчмаар сар бүр 1,000 RDX (Ардын Эрх) цуглуулахыг зорих бөгөөд цуглуулж дууссаны дараа 1,000 АрдКойн болгон хувиргаж авах боломжтой. 4-р сараас эхлэн манай өгөгдлийн шинжлэх ухааны баг тус хөтөлбөрт оролцогчдод сар бүр зорилгодоо хүрэхэд нь туслах үүднээс хувь хүний сонирхолд тохируулсан үйлчилгээг автоматаар санал болгох хөгжүүлэлтийг хийж эхлээд байна.

АрдКойны хэрэглээг улам нэмэгдүүлэх зорилгоор зээлжих зэрэглэлийн онооны загварыг АрдКойны хэрэглээнд суурилсан байдлаар дахин загварчилж, АрдКойн цуглуулах давтамж, хэмжээнээс хамааран зээлийн хэмжээ ихсэх, хүү багасах таатай нөхцөлтэй болголоо. Өгөгдлийн шинжлэх ухааны баг нь загвараа сайжруулахын тулд нэмэлт хүчин зүйлсийг багтааж, нарийвчлалыг сайжруулах зорилгоор МОСТ-той хамтран ажиллаж байна.

Энэ тайланг бичих мөчид бид долоо хоногийн туршид байгууллага дээрээ зохион байгуулах “Крипто долоо хоног” арга хэмжээндээ шаргуу бэлдэж байна. Энэхүү арга хэмжээний үеэр бид Нэгдлийн компаниудынхаа ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлууд болон бусад сонирхолтой уулзалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Та бүхнийг тус арга хэмжээнд оролцож, манай байгууллагаар зочлон, бидний үйл ажиллагаатай танилцахыг урьж байна.

Хүндэтгэсэн:

Батбилэгийн Золбоо

Гүйцэтгэх Захирал,
Ард Санхүүгийн Нэгдэл

Ард Кредит нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгож 1,200 гаруй хөрөнгө оруулагчдаас 8.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд уг гаргасан хувьцаа нь олон нийтэд санал болгохоос өмнөх нөхцөлөөр нийт хувьцааны 30 хувьтай, санал болгосны дараах нөхцөлөөр 23 хувьтай тэнцэж байна. Түүнчлэн, тус компанийн удирдлагын багт өөрчлөлт орж, Ард Кредит-д сүүлийн 7 жил ажилласан Г.Сүхбаатарыг Гүйцэтгэх захирлаар томилсон. Мөн тус компани Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос Финтек зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан нь онцлууштай үйл явдал боллоо.

Ард Актив Хадгаламж Зээлийн Хоршоо (ХЗХ)-ны нийт хөрөнгө эхний улиралд 25 хувиар өсч, 49 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд тус үзүүлэлтээр салбартаа 2-т эрэмбэлэгдэж байна. Тус хоршоо нь гишүүнчлэлийн бүртгэлийг автоматжуулах модулийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд Ард Апп хэрэглэгчдийг хоршооны гишүүн болгохоор зорин ажиллаж байна.

Одоогоор тус компани 4,400 гаруй гишүүнтэй.

Ард Лизинг энэ улиралд Ард Секюритиз компанитай хамтран ажиллаж бондыг амжилттай дахин санхүүжүүлэх тал дээр голлон ажиллаа. Мөн Ард Кредит-ыг үүсгэн байгуулагдсанаас нь хойш ажиллаж байсан Д.Мөнх-Од Ард Лизингийн Гүйцэтгэх захиралаар томилогдсон бөгөөд үндсэн лизингийн үйл ажиллагааг улам эрчимжүүлэхээр ажилдаа ороод байна.

Ардын Тэтгэвэрийн Данс компанийн удирдлагын багт өөрчлөлт орж, Ард Даатгалд нийт 7 жилийн турш ажилласан Ц.Тайширыг Гүйцэтгэх захирлаар томиллоо. Зах зээлийн уналт хөрөнгө оруулалтын багцад нөлөөлсөн хэдий ч Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон удирдлагын баг нь хөрөнгө оруулалтын багцдаа 4 хувийн өгөөжийг хуваарилах шийдвэргаргалаа. Хэдийгээр Хувийн тэтгэврийн тухай хууль хараахан батлагдаагүй байгаа ч тус компани тус хуульд тавигдаж болзошгүй шаардлагуудыг урьдчилан хангаж, хөрөнгө оруулалтын багцаа илүү оновчтой болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Ард Секюритизын хувьд энэ оны эхний улиралд 22.7 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь өнгөрсөн оны мөн үеийн 9 тэрбум төгрөгийн арилжаатай харьцуулахад нэлээдгүй нэмэгдсэн үзүүлэлт юм. Мөн компани Ард Кредитын нэмэлт хувьцаа гаргах ажилд чухал үүрэгтэй

Ард Секюритизын хувьд энэ оны эхний улиралд 22.7 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь өнгөрсөн оны мөн үеийн 9 тэрбум төгрөгийн арилжаатай харьцуулахад нэлээдгүй нэмэгдсэн үзүүлэлт юм. Мөн компани Ард Кредитын нэмэлт хувьцаа гаргах ажилд чухал үүрэгтэй оролцсоноос гадна Эрдэнэс Таван Толгой ХК (ЭТТ)-ийн ногдолшгийн хуваарилалтаар 5400 гаруй брокерийн данс нээж чадсан байна.

Өнгөрсөн онд манай хамаарал бүхий 27 компани Хөрөнгийн биржид бүртгэлтэй Өндөрхаан ХК-ний хувьцааг худалдаж авсан. Үүний зэрэгцээ Ард Санхүүгийн Нэгдэл нь Ардын Тэтгэврийн Данс ХХК-г болон ТэнГэрЛиг Медиа Нэгдэл, Монгол Шуудан ХК дэх эзэмшлийн хувьцаагаа тус компанируу шилжүүлсэн. Одоогийн байдлаар, бид тус компанид даатгалын кластерын бүтцийг бий болгохоор удирдлагын түвшинд шийдвэр гаргахаар ажиллаж байна.

Бид 2024 онд ГрэйпСити-тэй хамтран ERP болон BusinessIntelligence (BI) зэрэг технологид суурилсан удирдлагыг Нэгдлийн хэмжээнд нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулсан. Төслийн хүрээнд Ард Кредитийн одоогийн систем болон модулиудад суурилан туршилтаар нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү чухал ач холбогдол бүхий төслийг хэрэгжүүлэхэд манай ажилчдаас ихээхэн хүчин чармайлт шаардаж байгаа бөгөөд, бизнесийн үйл явцыг стандартжуулах, автоматжуулах боломжийг үүсгэх, мөн өгөгдөлд суурилсан хяналтыг бий болгоход чиглэсэн төслийг хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, хамтынажиллагаа болон шийдвэр гаргалт сайжирна. Ингэснээр аюулгүй байдлыг сайжруулахын зэрэгцээ үйл ажиллагааг бодит цагийн горимд хянах боломжтой болох юм.

Бүтцийн өөрчлөлт нь бидний чиглэлийг илүү тодорхой болгож өгөхөөс гадна хууль эрх зүйн болон үйл ажиллагааны хувьд ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, бизнесийн харилцааг жигдрүүлэхэд тусалж байна. Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд нийтдээ 50 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгийн шилжилтийг хийлээ.

Нэгдлийн хэмжээнд бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ нөхцөлийг сайжруулах, VIP үйлчилгээ үзүүлэх, түнш байгууллагуудад хөнгөлөлттэй үйлчлүүлэх замаар үнэ цэнтэй харилцагчид татахад анхааран ажиллаж байна. Харилцагчийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд Ард Суппорт нь Нэгдлийн одоогийн харилцагчдын хөрөнгийн хэмжээнд үндэслэн харилцагчдыг Элит болон Премиум зэрэглэлд ангилж, ялгаатай үйлчилгээг санал болгох ажлыг эхлүүлээд байна. Бид харилцагчидтайгаа харилцаагаа улам сайжруулах зорилгоор борлуулалтын менежерүүдийг томилон ажиллуулж байгаа бөгөөд ингэхдээ харилцагчдын хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн анхаарч байна. Ард Суппорт нь аялал, эрүүл мэнд, рестораны үйлчилгээг аутсорсинг хийх замаар консьержийн үйлчилгээг харилцагчдад санал болгож байна. Энэхүү санаачилга нь манай хөрөнгө удирдлагын болон хувийн банкны үйлчилгээний үндэс суурь болж байгаа юм. Мөн бид ажилчдаа Нэгдлийн санхүүгийн бүх бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад үр дүнтэй санал болгох, санхүүгийн төлөвлөлт хийхэд нь туслах чадамжтай мэргэшсэн санхүүгийн төлөвлөгч болгохоор бэлдэж байна. Үүний зэрэгцээ бид байгууллагын дотоод үйл ажиллагааг автоматжуулахын тулд харилцагчдыг сегментчилэх, ангилах ажлыг эхлүүлж, сегмент бүрт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож байна.

Чонын билэгдэл

Бөртэ чоно, Гуа маралын удамт, хөх толбот Монголчуудын сүр хүч, хийморь сүлдний бэлгэ тэмдэг. Хамгийн гэр бүлсэг, өөрийн сүрэгт насан туршдаа үнэнч байж, тэднийгээ хамгаалж явдаг онцлогтой эл амьтнаар Монгол эр хүний эрэмгий чанарыг дүйцүүлэн дүрсэлжээ.


Эх чоно

Сүргийн тэргүүний нөмөр түшгийг бараадан амьдардаг эмэгчний ёсыг сэрвээнд нь наалдан яваагаар илэрхийлжээ.




Үр төл

Амьтан бүхэн үр төлийнхөө төлөө зүрх сэтгэлээ өгч, тэмцэж амьдардгийг эцэг эхийнхээ зүрхэн тушаа хярсан бяцхан бэлтрэгийн дүрээр харуулжээ



Эцэг чоно

Сүргийн манлай эцэг чоно эмэгчнээ нуруундаа үүрч, үр төлөө зүрхэндээ тээж яваагаар дүрсэлжээ.



Хүний нөөц



2023 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд Гүйцэтгэх удирдлага, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт хийгдэж удирдлагын багийн 22 хувь өөрчлөгдөж, нийт 264 үндсэн ажилтан байна. Хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтан төвтэй, нээлттэй байдал, оролцоог илүү хүртээмжтэй болгох зорилгоор улирал тутам нэгдсэн судалгаа асуумжийг сэдэвчилсэн байдлаар зохион байгуулсан бөгөөд шинэчлэлт өөрчлөлтийн цаг үетэй нийцүүлэн бидний суурь зарчим Үнэт Зүйлсээ эргэн харах, шинэчлэн сэргээхээр нийт ажилтнуудын оролцоотойгоор шинэчлэн томьёолсныг онцолж байна. Энэ нь бидний үнэ цэн, чухалчлах зүйлсийг дахин тодорхойлж, итгэл үнэмшил зорилгыг нэгтгэж аливаа шийдвэр гаргах мөн чанар, чиг баримжааг олгох чухал ач холбогдолтой билээ.

- Бидний үнэлшгүй хөрөнгө баг хамт олон буюу - ХҮН капитал. Тиймээс нэгж, хэсэг бүлгийн онцлог, шинж чанар ялгаатай байдлыг харгалзан буюу хүйсийн (61 хувь эмэгтэй, 39 хувь эрэгтэй), насны (дундаж нас 34) болон үе хоорондын (62 хувь нь Миллениал, Z Ye) ажиллах арга барилд анхааран хувь хүний үнэ цэн, оролцоог хангах, тасралтгүй суралцах, хөгжих орчныг дэмжин дотоод/гадаад сургалт хөгжлийн хөтөлбөрүүдийг зохион байгуулснаас “Бид Хамтдаа Илүү Хөгжинө” уриан дор 3 сарын хугацаанд үргэлжилсэн Ард- Менторшип хөтөлбөрт оролцогчдын 33 хувь нь ахлах/ удирдлагын түвшинд албан тушаал дэвшин ажиллах болов.
- Хүний нөөцийн бүрдүүлэлт төдийгүй байгууллагын зах зээлд эзлэх байр суурь нэр хүндийг илэрхийлэх ажил олгогчийн брэнд, танигдалтайнд хүний нөөцийн бодлого, өрсөлдөх чадвар, онцгойрох зүйлээ бид олон нийтэд таниулан сурталчлах ажлын хүрээнд их дээд сургууль, ЕБС -ийн нийт 100 гаруй оюутан, сурагчдыг ажлын байрандаа хүлээн авч танилцах хөтөлбөр болон ажлын байрны чиг баримжаа олгох дадлагажигчаар ажиллах боломжийг нээлттэй олгодог. Уг ажлын үр дүнг хэмжих нэгэн үзүүлэлт болох Монголын шилдэг 8 их сургуулийн 500 гаруй оюутнуудын дунд хийсэн судалгаагаар төгсөөд ажиллахыг хүсэж буй ТОП 20 компанийн нэгээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК шалгарсан билээ.

Ирэх 3 жилд бизнес үйл ажиллагааны хурдацтай хөгжил дэвшил, өөрчлөлтийг баг бүрэлдэхүүний ур чадвар, арга барил, шинж чанарт тулгуурлан оролцоо энгэйжментийг өндөрт байлгах, гүйцэтгэл-чадамжид суурилсан үндсэн цалин хангамжийн багцаа улам сайжруулах буюу олон төрөл хэлбэрээр төрөлжүүлэх, тухайлбал байгууллагынхаа хувьцааг ажилтнууддаа эзэмшүүлэх хөтөлбөрийг анхлан хэрэгжүүлэгчийнхээ хувьд сайн туршлагаа улам өнгөлөн зах зээлд компанийнхаа ялгарал, давуу тал болгон хөгжүүлэхийг зорьж ажиллана.

Харилцагчийн үйлчилгээ

Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний охин компаниудын харилцагчийн үйлчилгээг хариуцдаг Ард Суппорт ХХК нь 2023 онд нийт 435,588 харилцагчид 6 сувгаар үйлчилгээ үзүүлсэн ба лавлах утасны шугамаар 217,564 харилцагчид үйлчилгээ үзүүлж зорилтот үр дүнг 99 хувь хангаж ажиллав. Дэлгэрэнгүй тоон үзүүлэлтээс дурдвал:

Үзүүлэлт	Харилцагч хандсан тоо	Асуудал шийдвэрлэлт ийн хувь
Нийт үйлчилгээ үзүүлсэн харилцагч	435,588	99%
Цахим сувгаар хүргэсэн мэдээлэл	79,893	100%
Бүх сувгаар бүртгэгдсэн гомдол	22,877	98%
Салбарын үйлчилгээ	11,630	100%
Оператортой холбогдож мэдээлэл авсан	217,564	99%
Автомат хариулагчаас мэдээлэл авсан	23,521	100%
Чатботоос лавлагаа, үйлчилгээ авсан	16,473	100%

Гадагшаа залгаж мэдээлэл хүргэсэн 86,507 92%



ГҮЙЦЭЭТГЭЭЛИЙН ТАЙЛАН



Ард Кредит

2024 оны эхний улиралд Ард Кредит ББСБ ХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон зөвшөөрлийн дагуу нэмэлт хувьцааг (FPO) олон нийтэд арилжаалж, 8.9 тэрбум төгрөгийг амжилттай босголоо. Анхдагч арилжааны үе шат 2-р сарын 15-наас 21-ний өдрийг хүртэл үргэлжилсэн бөгөөд нийт 1,583 хөрөнгө оруулагч оролцож 9.1 тэрбум төгрөгийн захиалга ирж 102.27% биелэлттэйгээр захиалга амжилттай хаагдсан байна. Нэмэлт хувьцаа гаргасны дараах байдлаар хувьцаа эзэмшигчдийн тоо 14,836 болж нэмэгджээ.

Мөн, Ард Кредит нь Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс, I ангилалд 5 жил дараалан багтаж байр сууриабататгав.

Тус компанийн ТУЗ-өөс 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангаарх цэвэр ашгийн 40.5 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг (нэг хувьцаанд 2.8 төгрөгтэй тэнцэх) хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн, Ард Кредит үйлчилгээг сайжруулж, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх үүргийнхээ хүрээнд АрдКойн эзэмшдэг, Ард Апп-ын үнэнч хэрэглэгчиддээ зориулан хэрэглээний онлайн зээлийн нөхцөлд шинэчлэл оруулж, зээлийн хүү, шимтгэлийг бууруулсан таатай нөхцөлийг санал болгож эхэллээ.

Ард Лизинг

Шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал компанийн ирэх гурван жилийн стратеги, бизнес төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, 2021 онд эхлүүлсэн үндсэн бүтээгдэхүүн болох "Өсдөг машин" хөтөлбөрийг дахин сайжруулж, зах зээлд санал болгохоор ажиллаж эхэллээ. Түүнчлэн, өнгөрсөн оны эцэст Ард Лизингийг амжилттай хөрөнгөжүүлсэн явдал нь Нэгдлийн зүгээс лизингийн үйл ажиллагааг сайжруулж, сарын мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх боломжийг болгоход анхаарсан явдал байлаа.

Ард Актив


2023 оны эцэс гэхэд Монгол Улс дахь хадгаламж зээлийн хоршоодын тоо 191 болж, тэдгээрийн нийт хөрөнгийн хэмжээ 307 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2023 оны байдлаар хадгаламж зээлийн хоршоодын нийт хөрөнгө өмнөх оноос 14%-иар буюу 39 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд Ард Активын хөрөнгийн өсөлт нь хадгаламж зээлийн хоршоодын нийт хөрөнгийн өсөлтийн 32%-ийг, нийт санхүүжилтийн 40%-ийг дангаар бүрдүүлсэн амжилттай байлаа.

Ард Актив нь 2024 оны I улиралд Бүх гишүүдийн ээлжит хурлаар амжилттай зохион байгуулсан бөгөөд тус хурлаар хүүхдийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхийг зорьж байгаагаа танилцуулав.

Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт 49.2 тэрбум төгрөгт хүрч 6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шинээр татаж, 4 тэрбум төгрөгийг дахин санхүүжүүлж, нийт 10 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлж, хадгаламжийн багцыг 37 тэрбум төгрөгт хүргэв. Түүнчлэн, 8 тэрбум төгрөгийн зээл олгож, нийт зээлийн багцыг 37.8 тэрбум төгрөгт хүргэв. Зээлийн багцийн 99.23 хувийг хэвийн зээл, 0.39 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 0.38 хувийг чанаргүй зээлийн багц эзэлж байна.

Тус ХЗХ эхний улиралд 2 тэрбум төгрөгийн нийт хүүгийн орлого олж, 258 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаа.

(сая төгрөг)	Гол үзүүлэлт	2023 У1	2023	2024 У1	Оны эхнээс	Жилийн өсөлт	
Ард Кредит	Нийт хөрөнгө	59,118.2	72,005.5	73,463.8	2.0%	24.3%	
	Нийт эздийн өмч	17,676.3	20,904.9	27,959.5	33.7%	58.2%	
	Зээлийн багц (цэвэр)	42,581.6	47,941.9	44,496.9	(7.2%)	4.5%	
	Санхүүжилт	30,807.8	39,294.5	33,849.6	(13.9%)	9.9%	
	Чанаргүй зээл	9.3%	7.1%	10.2%	43.7%	9.7%	
	Хугацаа хэтэрсэн зээл	17.2%	11.8%	16.4%	39.0%	(4.7%)	
	Цэвэр ашиг	238.4	2,518.7	385.4	(84.7%)	61.7%	
	Зээлийн багцын задаргаа:						
	Барьцаат зээл	7.7%	16.2%	15.8%	(2.5%)	105.2%	
	Цахим зээл	55.3%	49%	48%	(2.0%)	(13.2%)	
Ард Актив	Бизнесийн зээл	14.6%	9.9%	8.5%	(14.1%)	(41.8%)	
	СКОПА төслийн зээл	22.4%	24.9%	27.7%	11.2%	23.7%	
	Нийт хөрөнгө	31,889.6	43,971.8	49,143.7	11.8%	54.1%	
	Нийт эздийн өмч	8,249.7	8,804.2	9,073.9	3.1%	10.0%	
	Зээлийн багц (цэвэр)	25,247.8	34,744.6	37,734.0	8.6%	49.5%	
	Санхүүжилт	22,010.6	32,866.4	37,003.4	12.6%	68.1%	
	Чанаргүй зээл	1.90%	0.41%	0.38%	(7.3%)	(80.0%)	
	Хугацаа хэтэрсэн зээл	2.52%	0.42%	0.77%	83.3%	(69.4%)	
	Цэвэр ашиг	165.7	675.8	258.4	(61.8%)	55.9%	
	Зээлийн багцын задаргаа:						
Бизнесийн зээл	86.8%	89.6%	89.6%	0.0%	3.2%		
Цалингийн зээл	7.8%	3.9%	2.6%	(33.3%)	(66.7%)		
Хэрэглээний зээл	1.8%	0.9%	1.2%	33.3%	(33.3%)		
Барьцаат зээл	3.6%	5.6%	6.6%	17.9%	83.3%		
Ард Лизинг	Нийт хөрөнгө	36,873.0	55,812.4	42,422	(24.0%)	15.0%	
	Нийт эздийн өмч	(9,367.0)	141.2	(12,927.4)	(9,255.4%)	(38.0%)	
	Зээлийн багц (цэвэр)	4,036.3	1,809.9	1,854.6	2.5%	(54.1%)	
	Санхүүжилт	41,558.0	51,534.0	52,366.8	1.6%	26.0%	
	Цэвэр ашиг	(435.0)	(8,479.7)	(2,739.5)	67.7%	(529.8%)	



Ард Даатгал

2024 оны I улирал Ард Даатгалын хувьд санхүүгийн өндөр үзүүлэлтүүдийг үзүүлсэн улирал байлаа. Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос үүдсэн даатгалын тохиолдлын тоо нэмэгдэж олон сорилттой тулгарсан хэдий ч компани орлогоо тогтвортой өсгөж, даатгалын зах зээл дэх хүчтэй байр сууриахадгалж чадлаа.

Тус компанийн даатгалын хураамжаас олсон нийт орлого өмнөх онд 5.6 тэрбум төгрөг байсан бол энд онд 11.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Сүүлийн таван жилийн хугацаанд анх удаа агаарын хөлгүүд даатгалд хамруулснаар орлого их хэмжээгээр өслөө. Даатгалын тохиолдлын нийт тоо 3,410, нөхөн төлбөрийнхэмжээ 5.4 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийнхэмжээ 45.0 тэрбум төгрөгийг давлаа. Нээлттэй компанийн хувьд хувьцаа (MSE: AIC) 690.48 төгрөгөөр хаагдаж, зах зээлийнүнэлгээ нь 17 тэрбум төгрөгболлоо.

Компанийн эхний улирлын үйл ажиллагааны онцлох явдлуудаас дурдахад ТУЗ хоёр удаа хуралдаж, 4-р сарын сүүлч гэхэд мөнгөн дүнгээр нийт 750 сая төгрөгийн буюу нэгж хувьцаанд30 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэлээ. Түүнчлэн 1-р сард орон нутаг дахь салбар нэгжүүдийн ажилчидтай уулзалт хийж, сургалт зохион байгуулав. СЗХ-той хамтран ажиллаж"Компанийн засаглалын кодекс үнэлгээ"-гээ сайжруулж, орон нутгийн оюутан залууст зориулсан ЦАЛИНТАЙ ОЮУТАН хөтөлбөрийг санаачлан, Бангладеш Улсын Тайзерс ЭрсдэлийнМенежмент компанитай хамтранҮл хөдлөх хөрөнгийнэрсдэлийн семинарыг зохионбайгууллаа.

Ард Даатгал нь Монголын даатгалынхолбоо ТББ-тай хамтрандаатгалын талаарх олон нийтийн мэдлэгийгдээшлүүлэх, түүний ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Жилийн хамгийнтом 1% аян"-ыг хэрэгжүүлж байна.Хамтын ажиллагааны хүрээндМонголын томоохон гурванбанк, 29 ББСБ, мөн 27 мэргэжлийн даатгалынброкеруудтай байнгын хамтын ажиллагааг үргэлжлүүлж, хүнд өвчний даатгалыголон улсын даатгалынкомпаниудтай хамтран дотоодынзах зээлд нэвтрүүлэхийг зорин ажиллаж байна.

Ардын Тэтгэврийн Данс

Ардын Тэтгэврийн ДансныТУЗ-өөс тус компанийнудирдлагад өөрчлөлт оруулж,2024 оны 2-р сарын 29-нийөдрөөс эхлэн Ц.Тайширыг Гүйцэтгэх захирлаар томилохшийдвэр гаргалаа.

Эхний улирлын байдлаар компанийн хөрөнгө оруулалтын багц 43.1 тэрбум төгрөгт хүрч, хүүгийн орлогыг оролцуулан нийт 39.9 тэрбум төгрөгийн тэтгэврийн хуримтлалыг бүрдүүлээд байна.Тайлант хугацаанд 2.4 тэрбум төгрөгийнтэтгэврийн хуримтлал татсан нь өнгөрсөноны мөн үетэй харьцуулахад 6%-иар буурсан үзүүлэлттэй байгаа нь 2023 оны I улиралд нэг удаагийнх хэмжээний орлого орсон улирал байсантай холбоотой. Түүнчлэн, 490 сая төгрөгийн тэтгэврийн хуримтлал цуцлагдаж, 46 сая төгрөгийг харилцагчдад олгов. Тайлант хугацааныэцэст нийт 103 байгууллагын 141,252хүн тэтгэврийн хуримтлал эзэмшиж байна.

Хөрөнгө оруулалтын багцын хувьд 4.7% (2 тэрбум төгрөг) нь тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалт, 68.2% (29.4 тэрбум төгрөг) нь хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас, 22.5% (9.7 тэрбум төгрөг) нь альтернатив хөрөнгө оруулалт, 4.6% (1.98 тэрбум төгрөг) нь хаалттай компанийн хувьцаанаас тус тус бүрдэж байна. Компани нь 2024 оны I улиралд Монгэм фарма ХХК, Дэ Күүл Айс ХХК болон Эйр Тикет ХХК-тай хамтын ажиллагаа эхлүүлж, ажилчдыг нь гишүүнээр элсүүлсэн. Түүнчлэн компанийн нийт харилцагчдад Цагаан сар, Гэгээн Валентиныөдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийгхамгаалах өдрийг тохиолдуулан урамшууллууд зарласан байна.

Мөн компанийн 2024 оны Бизнес төлөвлөгөөнд Эрсдэлийн удирдлагыг чухалчилж ажиллахаар тусгасан бөгөөд тогтвортой Эрсдэлийн удирдлагын стратегийг хангах үүднээс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандартыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, Эрсдэлийнудирдлагын тогтолцоог боловсруулах, олон улсын тэтгэврийн сангуудтай хамтран ажиллахээрэгт анхааран ажиллажбайна.

(сая төгрөг)	Гол үзүүлэлт	2023У1	2023	2024У1	Оны эхнээс	Жилийн өсөлт
Ард Даатгал	Нийт хөрөнгө	36,038	44,156	47,199	6.9%	31.0%
	Нийт эздийн өмч	17,086	18,218	18,307	0.5%	7.1%
	Хөрөнгө оруулалтын багц	24,618	28,120	29,855	6.2%	21.3%
	Нийт хураамжийн орлого	5,464	32,438	10,940	(66.3%)	100.2%
	Нийт нөхөн олговор	2,537	14,095	5,424	(61.5%)	113.8%
	Цэвэр ашиг	407	3,277	89	(97.3%)	(78.0%)
Ардын Тэтгэврийн Данс	Нийт хөрөнгө	32,212	56,843	51,320	(9.7%)	59.3%
	Нийт эздийн өмч	(193)	14,916	6,248	(58.1%)	3,340.7%
	Хөрөнгө оруулалтын багц	29,750	49,689	43,133	(13.2%)	45.0%
	Нийт тэтгэврийн хуримтлал	29,284	37,249	39,940	7.2%	36.4%
	Тэтгэврийн хуримтлалын орлого	2,505	9,453	2,434	(74.3%)	(2.8%)
	Цэвэр ашиг (алдагдал)	(1,253)	(5,026)	(1,952)	61.2%	(55.7%)
	Нийт дэлгэрэнгүй орлого	(6,163)	(6,108)	(8,700)	(42.4%)	(41.2%)

(сая төгрөг)	Хөрөнгө оруулалтын багц	2022	2023	2024У1	Хувийн жин	Оны эхнээс
Ард Даатгал	Тогтмол өгөөжтэй	13,548	19,137	20,533	68.7%	7%
	Нээлттэй компанийн хөрөнгө оруулалт	6,662	4,838	4,838	16.2%	0%
	Альтернатив хөрөнгө оруулалт	3,616	2,625	2,994	10.0%	14%
	Бусад хөрөнгө оруулалт	0	1,520	1,520	5.1%	0%
	Нийт хөрөнгө оруулалтын багц	23,826	28,120	29,885	100%	6%
Ардын Тэтгэврийн Данс	Тогтмол өгөөжтэй	1,000	2,041	2,029	4.7%	(1%)
	Нээлттэй компанийн хөрөнгө оруулалт	20,994	36,092	29,419	68.2%	(18%)
	Альтернатив хөрөнгө оруулалт	7,255	9,581	9,707	22.5%	1%
	Үл хөдлөх	1,523	0	0	0.0%	
	Хаалттай компанийн хөрөнгө оруулалт	3,976	1,975	1,978	4.6%	0%
	Нийт хөрөнгө оруулалтын багц	34,748	49,689	43,133	100.0%	(13%)





Ажил аргачлалд суурилсан програм хангамж, хөгжүүлэлтийн стандартыг ашиглан Аппыг сайжруулах зорилгоор ГрэйпСити Монгол, МОСТ Финтек компаниудтай хамтарсан ажлын хэсэгтогтмол хоёр долоо хоногт нэг удаа аппикэйшны шинэчлэлтийг гарган ажиллаж байна.

2023 оын 12 сард санаачлан эхлүүлсэн Түмэн Ард хөтөлбөр нь Ард Аппын хэрэглээг нэмэгдүүлэх, ашиг тусыг нь олон нийтэд таниулах зорилготой бөгөөд энэхүү хөтөлбөр нь Ард Аппаар дамжуулан хэрэглэгч хадгаламж, хөрөнгө оруулалтаа удирдах дадал зуршлыг хөгжүүлэхэд чиглэсэн. Хэрэглэгч Ард Аппыг тогтмол ашигласнаар сар бүр 1,000 ардын эрхийг цуглуулах боломжтой байдаг ба ардын эрхийг тогтмол цуглуулдаг харилцагчдын тоо өссөөр байгаа бөгөөд, тэр дундаа сар бүр тогтмол 1,000 ардын эрхээ цуглуулдаг хэрэглэгчдийн тооогцом өссөөр байна. 2024 оны 1-р улирлын байдлаар Түмэн Ард хөтөлбөрт хамрагдсан гишүүдийн тоо 3,473 хүрсэн ба үүнээс Ардын Элч 19, Ардын Ноён 878, Ардын Брокер 2,576 болсон байна. Мөн гишүүддээ тогтмол мэдээлэл хүргэх зорилгоор онлайн уулзалт 4, нээлттэй сургалт 4, Ардын Элчүүдийн уулзалт 2 удаа тус тус зохион байгуулсан.

	2023 У1	2023	2024 У1	Жилийн өсөлт
Ард Апп нийт хэрэглэгч	1,076,115	1,104,180	1,119,889	4.1%
Ард Апп шинэ хэрэглэгч	12,898	28,065	15,709	21.8%
Ард Кидс хэрэглэгч	43,675	52,515	53,637	22.8%
Нийт гүйлгээний тоо	452,151	3,635,595	904,087	100.0%
Хадгаламж (тэрбум төгрөг)	5.5	31.5	5.6	1.8%
Олгосон цахим зээл (тэрбум төгрөг)	15.8	75.3	15.2	(3.8%)
Хувьцааны арилжаа (тэрбум төгрөг)	3.9	16.2	4.7	20.5%
Нийт шилжүүлэг (тэрбум төгрөг)	87.9	401.7	110.0	25.1%

	Ард Апп	Ард Кидс
Шинэ хэрэглэгч (зөвхөн IOS үйлдлийн систем)	37,566	2,055
Шинэ хэрэглэгч (зөвхөн Android үйлдлийн систем)	19,721	743

	2023 У1 Дундаж	2023 У4 Дундаж	2024 У1 Дундаж	Жилийн өсөлт
Идэвхтэй хэрэглэгч - өдрөөр (> өдөрт 1 гүйлгээ)	1,984	2,566	2,456	23.8%
Идэвхтэй хэрэглэгч - 7 хоногоор (> 7 хоногт 1 гүйлгээ)	7,082	9,308	8,814	24.5%
Идэвхтэй хэрэглэгч - сараар (> сард 1 гүйлгээ)	12,973	24,104	25,841	99.2%

	2023 У1 Дундаж	2023 У4 Дундаж	2024 У1 Дундаж	Жилийн өсөлт
Идэвхтэй хэрэглэгч - өдрөөр (> өдөрт 1 удаа нэвтрэх)	9,984	18,690	19,880	99.1%
Идэвхтэй хэрэглэгч - 7 хоногоор (> 7 хоногт 1 удаа нэвтрэх)	20,767	22,838	25,816	24.3%
Идэвхтэй хэрэглэгч - сараар (> сард 1 удаа нэвтрэх)	30,767	36,319	55,947	81.8%

1,000 RDX-д хүрсэн хэрэглэгчид сард дунджаар 350 мянган төгрөгийн хадгаламж/хөрөнгө оруулалт хийж байна.

	2023 У1 Дундаж	2023 У4 Дундаж	2024 У1 Дундаж	Жилийн өсөлт
Нийт хэрэглэгч - 1,000 RDX-д хүрсэн	445	889	876	96.9%
Нийт хэрэглэгч - цуглуулсан RDX	13,524	13,000	13,347	(1.3%)

Хөрөнгө оруулалтын багц




Банк


ББСБ
 КРЕДИТ
 ББСБ



Лизинг
 ЛИЗИНГ
 КОМПАНИ




ХЗХ
 АКТИВ
 ХЗХ



Даатгал

Ердийн даатгал
 | ДААТГАЛ
 SINCE 1994



Өндөрхаан ХК




Тэтгэврийн сан
 ТЭТГЭВРИЙН
 ДАНС



Хөрөнгө оруулалтын банк

ХОМК
 МЕНЕЖМЕНТ
 КОМПАНИ




Хаалттай сан
 NATIONAL
 PRIVATIZATION
 FUND




Нээлттэй сан
 ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
 ҮНДЭСТЭН
 БАЛГИЙН САН



ҮЦК
 СЕКЮРИТИЗ
 ҮЦК



Үл хөдлөх
 ПРОПЕРТИЗ
 КОМПАНИ



Бусад


Хөвсгөл ХК




Медиа нэгдэл
 ТЭНГЭРЛИГ
 МЕДИА ГРУПП




Үнэт цаасны бирж
 UBX



Блокчэйн
 CRYPTO
 NATION



Програм хангамж
 GrapeCity
 Mongolia



Шуудан



Төлбөрийн платформ



Ард Санхүүгийн Нэгдлийн
 ЭЗЭМШИЛ

Холбоотой этгээдийн
 ЭЗЭМШИЛ

МХБ дээр нээлттэй компани



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ - AARD



#	Хувьцаа эзэмшигч	2023.12.31	%	2024.03.30	%	Улирлын өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
1	И Ай Ти ХХК	2,775,406	9.70%	3,045,406	10.64%	270,000	0.94%
2	Ардын Тэтгэврийн Данс ХХК*	2,517,778	8.80%	2,666,294	9.32%	148,516	0.52%
3	Бруно Рашле	2,109,997	7.37%	2,109,997	7.37%	0	0.00%
4	А.Сүхдорж	1,944,990	6.80%	1,944,990	6.80%	0	0.00%
5	Ч.Ганхуяг	1,590,466	5.56%	1,591,006	5.56%	540	0.00%
6	Ард Венчурс ХХК	1,429,244	4.99%	1,159,244	4.05%	(270,000)	(0.94%)
7	Г.Уянга	1,389,754	4.86%	1,389,754	4.86%	0	0.00%
8	Голомт Кастодиан Банк	900,000	3.15%	900,000	3.15%	0	0.00%
	ARDT	900,000	3.15%	900,000	3.15%	0	0.00%
9	Ард Лизинг	680,976	2.38%	758,612	2.65%	77,636	0.27%
10	Ард Кредит ББСБ	525,489	1.84%	433,414	1.51%	(92,075)	(0.32%)
11	С.Гэрэлтуяа	455,935	1.59%	455,935	1.59%	0	0.00%
12	Ронк Лимитед	443,816	1.55%	443,816	1.55%	0	0.00%
13	Ард Секюритиз ҮЦК	400,988	1.40%	382,832	1.34%	(18,156)	(0.06%)
14	С.Оргил	390,937	1.37%	390,937	1.37%	0	0.00%
15	Г.Бат-Эрдэнэ	351,268	1.23%	351,268	1.23%	0	0.00%
16	Н.Мөнхнасан	344,311	1.20%	344,311	1.20%	0	0.00%
17	Масик Энтерпрайзес	321,078	1.12%	321,078	1.12%	0	0.00%
18	Х.Батхишиг	319,346	1.12%	319,346	1.12%	0	0.00%
19	Ард Даатгал	253,265	0.89%	253,265	0.89%	0	0.00%
20	Д.Отгонбаяр	233,303	0.82%	233,303	0.82%	0	0.00%
	Топ 20	19,378,347	67.72%	19,494,808	68.13%	116,461	0.41%
	Бусад	9,235,916	32.28%	9,119,455	31.87%	(116,461)	(0.41%)
	Эргэлтэд буй хувьцаа	28,614,263	100%	28,614,263	100.00%	0	0.00%
	Халаасны хувьцаа						
	Нийт гаргасан хувьцаа	28,614,263					-
	Хувьцаа эзэмшигчид	19,069		19,043		(26)	
	ARDT эзэмшигчид	3,061		3,077		16	
	ADT эзэмшигчид (хүүхдүүд)	55,166		57,016		1,850	

Ардын Тэтгэврийн Данс* - Кастодиан дээр хадгалагдаж буй

ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН



(сая төгрөг)	2023У1	2023	2023 (Аудитлагдсан)	2024У1	2024У1 (Төсөв)	Оны эхнээс	Жилийн өсөлт
Менежментийн орлого	476	1,886	1,886	842	807	(55.4%)	77.0%
Хөрөнгө оруулалтын орлого	0	7,192	5,969	0		(100.0%)	
Ногдол ашгийн орлого	0	45	45	0		(100.0%)	
Хүүгийн орлого	50	1,052	1,067	15	136	(98.6%)	(70.0%)
Нийт хөрөнгө оруулалтын орлого	525	10,175	8,967	856	943	(90.4%)	63.1%
Бусад орлого	620	3,070	3,024	63		(97.9%)	(89.9%)
Нийт орлого	1,145	13,245	11,992	919	943	(92.3%)	(19.7%)
Борлуулалт, маркетингийн зардал	115	1,849	1,193	19	95	(98.4%)	(83.8%)
Үйл ажиллагааны зардал	1,168	7,831	7,776	1,481	1,855	(81.0%)	26.8%
Санхүүгийн зардал	623	3,651	3,642	826	785	(77.3%)	32.6%
Бусад зардал	126	403	396	76		(80.9%)	(40.1%)
Нийт зардал	2,033	13,734	13,007	2,401	2,735	(81.5%)	18.1%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	9	(102)	(103)	0		100.0%	100.0%
Бусад олз (гарз)		0	(1,497)	0		100.0%	
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(896)	(387)	585	(1,482)	(1,791)	(353.5%)	(65.4%)
Орлогын албан татварын зардал	(16)	(534)	470	1		(99.7%)	109.3%
Цэвэр ашиг	(880)	148	115	(1,484)	(1,791)		(68.5%)
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз (гарз)	(14,831)	(19,474)	(19,466)	(6,470)		66.8%	56.4%
Нийт дэлгэрэнгүй орлого	(15,711)	(19,326)	(19,350)	(7,954)	(1,791)	58.9%	49.4%

ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ



Хүчтэй. Хамтдаа.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН



(сая төгрөг)	2023У1	2023У1	2023 (Аудитлагдсан)	2024У1	2024У1 (Төсөв)	Оны эхнээс	Жилийн өсөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		3	329	329	56	24 (83.1%)	1,820.7%
Дансны болон бусад авлага	19,669	55,207	53,550	52,367	24,542	(2.2%)	166.2%
Бусад санхүүгийн хөрөнгө	915	689	705	671	1,035	(4.9%)	(26.7%)
Бараа материал	90	104	104	104		(0.4%)	14.8%
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	5,093	7,478	10,940	9,182	6,090	(16.1%)	80.3%
Нийт эргэлтийн хөрөнгө	25,770	63,807	65,628	62,379	31,691	(5.0%)	142.1%
Үндсэн хөрөнгө	585	452	429	412	668	(4.0%)	(29.6%)
Биет бус (Виртуал) хөрөнгө	13,613	262	262	371	157	41.4%	(97.3%)
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,052	544	460	413		(10.2%)	(60.7%)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	79,986	80,654	82,163	78,321	95,875	(4.7%)	(2.1%)
Нийт эргэлтийн бус хөрөнгө	95,236	81,912	83,314	79,516	96,700	(4.6%)	(16.5%)
НИЙТ ХӨРӨНГӨ	121,005	145,719	148,942	141,895	128,391	(4.7%)	17.3%
Дансны болон бусад өглөг	7,218	20,770	21,835	30,823	17,950	41.2%	327.0%
Богино хугацаат өр төлбөр	2,183	2,511	6,852	2,495	5,902	(63.6%)	14.3%
Богино хугацаат бондын өглөг	1,020	370	370	370	370	0.0%	(63.7%)
Богино хугацаат түрээсийн өглөг	642	608	608	374		(38.6%)	(41.9%)
Урьдчилж орсон орлого	9,874	11,649	19,408	9,799	11,266	(49.5%)	(0.8%)
Нийт богино хугацаат өр төлбөр	20,938	35,908	49,073	43,859	35,489	(10.6%)	109.5%
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	608	0	0	0			(100.0%)
Урт хугацаат зээл	6,492	16,535	12,193	13,583	12,964	11.4%	109.2%
Хойшлогдсон татварын өр	4,466	4,023	3,413	3,301	3,321	(3.3%)	(26.1%)
Нийт урт хугацаат өр төлбөр	11,566	20,558	15,607	16,884	16,285	8.2%	46.0%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	32,504	56,466	64,680	60,743	51,774	(6.1%)	86.9%
Өмч-хувьцаат	28,614	28,614	28,614	28,614	28,614	0.0%	0.0%
Нэмж төлөгдсөн капитал	2,928	2,928	2,928	2,928	2,928	0.0%	0.0%
Дахин үнэлгээний нөөц	37,309	33,319	28,362	26,849	18,061	(5.3%)	(28.0%)
Эздийн өмчийн бусад хэсэг	14	14	14	14	14	0.0%	0.0%
Хуримтлагдсан ашиг	19,637	24,378	24,344	22,746	27,000	(6.6%)	15.8%
Эздийн өмч	88,502	89,252	84,262	81,151	76,617	(3.7%)	(8.3%)



Ардын үнэнч харилцагч танд...


Хүчтэй. Хамтдаа.

(сая төгрөг)	Суурь	2022	%	2023 (Аудитл агдсан)	%	2024У1	%	Оны эхнээс
Стратегийн хөрөнгө оруулалт		91,698		76,749		72,908		(5.0%)
Ард Кредит (MSE: ADB)	MV	14,630	41%	13,747	41%	17,725	47%	28.9%
Ард Актив	BV	804	10%	877	10%	904	10%	3.1%
Ард Лизинг	Cost	1	100%	18,197	100%	18,197	100%	0.0%
Ард Даатгал (MSE: AIC)	MV	10,535	45%	9,950	45%	7,856	46%	(21.0%)
Өндөрхаан	MV			620	23%	325	23%	(47.6%)
Ардын Тэтгэврийн Данс	BV	0	0%	0	0%	0	0%	
Ард Секюритиз	BV	5,644	90%	5,849	90%	5,347	90%	(8.6%)
Ард Менежмент	BV	1,870	90%	2,807	100%	2,548	100%	(9.2%)
Ард Пропертиз	BV	4,788	100%	4,783	100%	4,812	100%	0.6%
ТэнГэр Системс	BV	1,076	100%	0	100%	0	100%	
Монгол Шуудан (MSE: MNP)	MV	16,008	20%	7,999	9%	6,523	9%	(18.5%)
Хөвсгөл	MV			6	93%	7	93%	18.1%
Ард Венчурс	BV	0	0%	0	0%	0	0%	
Ард Бит	BV	0	0%	0	0%	0	0%	
Айдакс	DCF	0	0%	0	0%	0	0%	
Даац Инвестмэнт (УБҮЦБ-ийн 54%)	Cost	4,096	51%	4,096	51%	4,096	51%	0.0%
ТэнГэрЛиг Медиа Нэгдэл	MV	22,737	38%	6,605	11%	3,769	11%	(42.9%)
ГрэйпСити Монгол	Cost							
МОСТ Финтек (UBX: MOST)	MV			1,213	4%	799	3%	(34.1%)
Тактикийн хөрөнгө оруулалт		1,069		6,120		6,085		(0.6%)
Үндэсний Хувьчлалын Сан (MSE: ХОС)	MV	26	0%	44	1%	43	1%	(2.3%)
КриптоҮндэстэн	MV	589	6%	7	0%	7	0%	(6.3%)
Бусад санхүүгийн хэрэгслүүд		454		6,069		6,035		(0.6%)
Бусад		40,015		4,807		5,460		13.6%
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө		13,632		1,151		1,195		3.8%
Бэлэн мөнгө		4		329		56		(83.0%)
Бусад цэвэр хөрөнгө		26,379		3,327		4,209		26.5%
Нийт үнэлгээ		132,781		87,676		84,453		(3.7%)
Нэгж хувьцааны үнэлгээ		4,640		3,064		2,951		(3.7%)
Зах зээлийн үнэлгээ		4,880		3,506		2,987		(14.8%)
		5%		14%		1%		


ОРЛОГЫН ТАЙЛАН




MSE: ADB арилжаа



MSE: AIC арилжаа



MSE: MNP арилжаа



Тикер	2024У1 (Улирлын)		52-week		2024У1 (Улирлын)		52 долоо хоног		2024.03.30	
	Дээд	Доод	Дээд	Доод	Арилж ааны дүн	Эргэц %	Арилж ааны дүн	Эргэц %	Хаалты н ханш	33Ү
AARD	3,450.0	2,900.0	3,650.0	2,900.0	2.53B	2.90%	8.47B	9.43%	2,987	85.47B
AIC	839.8	670.1	950.0	670.1	0.6B	3.38%	1.37B	7.16%	690.48	17.26B
ADB	122.0	101.0	139.0	97.0	0.89B	2.30%	2.59B	6.22%	104.23	37.94B
MNP	922.0	600.0	975.0	600.0	0.86B	1.06%	1.47B	1.79%	709	70.61B
TNGR	9,890.0	5,900.0	12,000.0	5,900.0	0.51B	1.21%	0.97B	2.08%	6,010	36.06B
CNF	77,800.0	42,080.0	80,000.0	42,080.0	0.52B	8.97%	1.4B	22.37%	69,000	7.81B
XOC	105.0	91.1	115.9	91.1	0.14B	2.96%	0.44B	8.78%	102.93	5.15B
					% of MSE	2.72%	0.00%			
MOST	54.0	40.0	55.7	40.0	0.93	4.87%	1.55	7.75%	48	23.33B
					% of UBX	95.22%	95.92%			



Хувьцаа эзэмшигч	Өөрчлөлт, тоо
ХК	Хувьцаат Компани
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
ББСБ	Банк Бус Санхүүгийн Байгууллага
ХЗХ	Хадгаламж Зээлийн Хоршоо
ҮЦК	Үнэт Цаасны Компани
УБҮЦБ	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж эсвэл Ulaanbaatar Exchange буюу UBX
AARD	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа
AIC	Ард Даатгал ХК-ийн хувьцаа
ADB	Ард Кредит ХК-ийн хувьцаа
ХОС	Үндэсний Хувьчлалын сангийн нэгж эрх
CNF	Крипто Үндэстэн ХК-ийн хувьцаа
MNP	Монгол шуудан ХК-ийн хувьцаа
TNGR	ТэнГэрЛиг Медиа Нэгдэл ХК-ийн хувьцаа
MOST	МОСТ Финтек ХК-ийн хувьцаа
ХОҮС	Хөрөнгө Оруулагч Үндэстэн сангийн нэгж эрх
ARDT	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцааны токенжуулсан хэлбэр
CupCake	Худалдан авалтын хариултаа хадгалах үйлчилгээ
Pick n Pay	Ардын харилцагчид хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүүгүй, шимтгэлгүй хуваан төлөх
Ардын Эрх	Оноо цуглуулан, АрдКойн руу хөрвүүлэн авах урамшуулалт хөтөлбөр
Ард Апп	Санхүүгийн цогц үйлчилгээг агуулсан, лайф-стайл супер апп
АрдКидс	Хүүхдийн анхны санхүүгийн апп
YoY	Year-on-year буюу өмнөх жилийн мөн үеэс хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлнэ
YTD	Year-to-date буюу оны эхнээс хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлнэ
CAGR	Compound annual growth rate буюу нийлмэл жилийн дундаж өсөлт



**АРДЫН БҮХ
МЕРЧАНТ
АРДКОЙНООР
УРАМШУУЛДАГ
БОЛЛОО**

www.ardcoin.com